

# ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИЙН ТУНХАГЛАЛ (ХЭХТ)

## ХЭХ-ИЙН ЭРХ

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүний эрхийн хамгаалагчийн тунхаглалд хүн бүр тайван замаар хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих эрхтэй. (1,11 дүгээр зүйл)

### ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧ (ХЭХ)-ИЙН ХУВЬД ӨӨРИЙН ЭРХЭЭ МЭДЭХ НЬ АМИН ЧУХАЛ.

ТА ЭРХЭЭ МЭДСЭНЭЭР ӨӨРИЙГӨӨ БОЛОН БУСАД ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДЫГ ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ, ХАЛДЛАГААС ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ АВЧ ЧАДНА.

## ЭРХЭЭ МЭДЭХ НЬ

АЗИЙН ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДАД ТОХИОЛДОЖ БУЙ ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ, ДАРАМТЫН ТҮГЭЭМЭЛ ХЭЛБЭР БОЛОН ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИД ӨӨРСДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХАД АШИГЛАЖ БОЛОХ ХЭХТ-ЫН ЗААЛТУУД

### ДАРАМТ ШАХАЛТЫН ЧИГ ХАНДЛАГА



### ТАНЫ ЭРХ

Зарим улс орнуудад хүмүүсийг тайван жагсаал, цуглаанд оролцох эсвэл зохион байгуулсны төлөө хууль бусаар баривчилж байна.

Хүний эрхийн зөрчлийг эсэргүүцэж жагсаал, цуглаан хийх эрхтэй. (5,12.1 -р зүйл)

Зарим улс орнуудад ТББ-уудын бүртгэлийн үйл явцыг зориуд сунжруулан удаашруулах, ТББ-уудын гэрчилгээг хууль бусаар хүчингүй болгох тохиолдол түгээмэл байна.

Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих чиглэлээр ажиллаж буй аливаа байгууллага эсвэл бүлгүүдэд нэгдэх, оролцох эрхтэй. ( 5 дугаар зүйл)

Тодорхой улс орнуудад хүний эрхийн асуудлыг олон нийтийн дунд хэлэлцүүлсний төлөө хүний эрхийн хамгаалагчид халдлага, дарамтад өртөж байна.

Хүний эрхийн ойлголт, зарчмуудыг боловсруулах, хэлэлцэх, хөхиүлэн дэмжих эрхтэй. (7 дугаар зүйл)

Цөөн улс оронд хүний эрхийн хамгаалагчдад хүний эрхийн ажлыг явуулахад шаардлагатай нөөц боломжийн хүртээмжийг хязгаарладаг.

Хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих зорилгоор шаардлагатай нөөц боломжийг хаанаас ч хүлээн авах болон ашиглах эрхтэй. (13-р зүйл)

Хүн бүрийн эрхийг хамгаалах, хангахад гол үүрэгтэй хүний эрхийн хамгаалагчдыг эрүүгийн хариуцлагад татах зэргээр тэдний эсрэг байнга гарч байгаа хүчирхийллийг арилгах асуудалд анхаарах нь нэн чухал гэж Форум-Ази үзэж байна. Иймээс ХЭХТ батлагдсаны 20 жилийн ойн босгон дээр хүний эрхийн хамгаалагчдын ач холбогдол, тэдний оруулж буй хувь нэмэр, ХЭХТ-д заасан хүний эрхийн хамгаалагчдын эрх, тэдний талаар бусад талуудын хүлээсэн үүрэг хариуцлагыг олон нийтэд таниулах зорилгоор Форум-Ази үзүүлэн таниулах материалыг гаргаж байна.